



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/206

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1 дэх заалт, Ховд аймгийн онцгой комиссын 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2019 оны 1 дүгээр улирлын гамшиг осол, аюулт үзэгдлийн үед сумдад дэмжлэг үзүүлэх чиглэлээр аймгийн Онцгой комиссоос гаргасан шатахууны зардалд 1 465 750 төгрөг, голын усны тэлэлттэй холбоотой голын усны гольдрол өөрчилж хамгаалалт далан босгоход зарцуулсан материалын зардалд 600 000 төгрөг, Үерийн улмаас тасарсан Ховд, Эрдэнэбүрэн сумын чиглэлийн мэдээлэл холбооны сүлжээний шилэн кабелийг засварлаж төрийн болон аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн хэвийн үйл ажиллагааг хангаж засварлах материалын зардалд 849 798 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 915 548 төгрөг /Хоёр сая есөн зуун арван таван мянга таван зуун дөчин найман/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гамшгаас хамгаалах зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/206 Ch

02 00984